



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Цахим систем ашиглан иргэдийн  
оролцоог хангах, санал авах  
журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1.4</sup> дэх хэсгийг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР



Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01 дугаар тогтоолын хавсралт

## ЦАХИМ СИСТЕМ АШИГЛАН ИРГЭДИЙН ОРОЛЦОOG ХАНГАХ, САНАЛ АВАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Улсын Их Хурал шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангах, иргэд Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал өгөх эрхээ Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим систем (цахим хуудас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан программ хангамж)-ээр дамжуулан эдлэх, иргэдийн оролцоотой цахим зөвлөгөөн зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

### Хоёр.Цахим системээр санал авах хүрээ, хязгаар

2.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1.2</sup> болон энэ журамд заасан хугацаа, нөхцөлийн дагуу дор дурдсан хүрээ, хязгаарын хүрээнд цахим системээр санал авах үйл ажиллагааг явуулна:

- 2.1.1.тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах;
- 2.1.2.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах;
- 2.1.3.хуулийн төслийн талаарх санал.

2.2.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд заналхийлсэн, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, түүнд илтэд халдсан асуудлаар иргэн санал гаргах, иргэдээс санал авахыг хориглоно.

2.3.Нэг саналд өөр хоорондоо хамааралгүй хэд хэдэн асуудал тусгахыг хориглоно.

2.4.Энэ журмын 4.2-т заасны дагуу холбогдох Байнгын хороо хэлэлцсэн тохиолдолд тухайн асуудлаар б сарын хугацаанд дахин санал авах үйл ажиллагаа явуулахгүй.

### Гурав.Цахим систем ашиглан иргэн санал гаргах үйл ажиллагаа

3.1.Иргэн цахим системд танилт, нэвтрэлтийн систем ашиглан нэвтэрч, тодорхой асуудлаар санал гаргах болон санал өгч болно.

3.2.Цахим системээр санал авах үйл ажиллагаа 2 үе шаттай байна.

3.3.Эхний шатанд иргэн цахим системд энэ журмын 2.1.1-2.1.3-т заасан асуудлаас сонгож саналаа гаргана.

3.4.Энэ журмын 2.1-д заасан санал нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- 3.4.1.сэдэв бичих;
- 3.4.2.үндэслэл, тайлбар бичих;
- 3.4.3.өс бус үг хэллэг хэрэглэхгүй байх.

3.5.Энэ журмын 3.4-д заасан шаардлага хангаж, 100 иргэний дэмжлэг авснаар хоёр дахь шатны санал авах үйл ажиллагаа эхлэх бөгөөд саналыг санал авах цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулна.

3.6.Хэрэв иргэдийн санал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup>.2-т заасан тоонд хүрсэн бол санал авах үйл ажиллагааг энэ журмын 3.5-д заасан хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

3.7.Санал авах үйл ажиллагаанд Улсын Их Хурлын Тамгын газар (цаашид “Тамгын газар” гэх) мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхдээ дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.7.1.энэ журмын 3.5-д заасан санал авах үйл ажиллагаа эхэлсэн талаар нийтэд хүртээмжтэй хэлбэрээр зарлан мэдээлэх;

3.7.2.санал авах үйл ажиллагааны явцын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэх;

3.7.3.саналын үр дүнг олон нийтэд шуурхай, үнэн зөв мэдээлэх;

3.7.4.санал авах үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.7.5.иргэдээс санал авах цахим системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;

3.7.6.энэ журмын 2.2, 3.4.3-т хяналт тавих;

3.7.7.цахим системд нэвтэрсэн, санал гаргасан, өгсөн талаарх мэдэгдлийг цахимаар хүргэнэ.

3.8.Энэ журмыг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааг хориглоно:

3.8.1.цахим системд санал өгөх явцад бусдыг гүтгэх, доромжлох, гутаах зэрэг мэдээ, мэдээлэл түгээх;

3.8.2.цахим системд санал өгөх явцад хүний хувийн, эмзэг мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр нийтлэх.

### **Дөрөв.Санал авах үйл ажиллагааг дүгнэх, үр дүнг тооцох**

4.1.Санал авах үйл ажиллагааны үр дүнг Тамгын газар ажлын 3 хоногт багтаан Улсын Их Хурлын даргад хүргүүлнэ.

4.2.Энэ журмын 3.5, 3.6-д заасан шаардлагыг ээлжит чуулганы үеэр хангасан бол 14 хоногийн дотор, ээлжит чуулганы чөлөө цагт хангасан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор холбогдох Байнгын хороо авч хэлэлцэх бөгөөд дор дурдсан шийдвэрийг гаргана:

4.2.1.тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах;

4.2.2.бодлогын баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх;

4.2.4.Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах;

4.2.5.хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.

4.3.Энэ журмын 4.2-т заасан асуудлыг холбогдох Байнгын хороо шийдвэрлэж, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулна.

4.4.Хуулийн төслийн талаарх саналыг 100000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол Улсын Их Хурлын дарга уг асуудлын талаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлж, холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

4.5.Байнгын хороо энэ журмын 4.2-т заасан асуудлыг хэлэлцэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Хууль тогтоомжийн тухай хуулийг баримтална.

### **Тав.Цахим зөвлөгөөн зохион байгуулах**

5.1.Улсын Их Хурал шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангах зорилгоор цахим систем ашиглан цахим зөвлөгөөнийг дараах зорилгоор зохион байгуулна:

5.1.1.нийгэм, эдийн засгийн тулгамdsan асуудлыг иргэдийн оролцоотойгоор тодорхойлох;

5.1.2.тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх;

5.1.3.иргэд, олон нийтэд тулгамdsan асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх;

5.1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд заасан төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах.

5.2.Цахим зөвлөгөөнийг зохион байгуулах шийдвэрийг Улсын Их Хурлын даргын захирамжаар, эсхүл холбогдох Байнгын хорооны тогтоолоор гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

5.3.Энэ журмын 5.2-т заасан шийдвэрт дараах асуудлыг тусгана:

5.3.1.цахим зөвлөгөөний сэдэв;

5.3.2.цахим зөвлөгөөнийг зохион байгуулах хугацаа;

5.3.3.цахим зөвлөгөөний төсөв;

5.3.4.үр дүнг тайлагнах.

5.4.Цахим зөвлөгөөнийг холбогдох Байнгын хороо олон нийтийн ашиг, сонирхлыг төлөөлөх бүрэлдэхүүн бүхий Зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

5.5.Цахим зөвлөгөөн хоёр үе шаттай байж болно.

5.6.Зөвлөлийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулна.

5.7.Тамгын газар нь Зөвлөлийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.8.Цахим зөвлөгөөнийг зохион байгуулах, санал авахад холбогдох бусад байгууллагыг оролцуулж болно.

5.9.Цахим зөвлөгөөний үр дүнг иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг холбогдох Байнгын хороо зохион байгуулна.

---оОо---